



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 8/35

Улаанбаатар хот

Г Тооллогын комисс байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.2.1, 70.2.2, 71 дүгээр зүйлийн 71.1, 72 дугаар зүйлийн 72.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1, 12.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2022 оны эхний хагас жилийн тайлан гаргахтай холбогдуулан байгууллагын эд хөрөнгөд 2022 оны 2-р улирлын тооллого явуулах комиссийг хавсралт ёсоор баталсугай.
2. Тооллогын бэлтгэл ажлыг ханган хуваарь гарган батлуулж, хуваарийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 15-наас 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж тооллогын дүнг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг комиссын ахлагч Л.Мөсчихэр, Ерөнхий нягтлан бодогч М.Мөнхтулга нарт тус тус даалгасугай.
3. Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэл хөтлөлт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллахыг комиссийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДУУ

Л.ДЭЛГЭР

Нийтлэг үйлчилгээний газрын даргын  
2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн  
1/25 дугаар тушаалын хавсралт

Комиссын ахлагч:

Л.Мөсчихэр  
Албаны дарга

Гишүүд:

Б.Хэнмэдэх  
Дотоод хяналт хариуцсан ажилтан

Б.Батсүрэн  
Ерөнхий инженер

Б.Мөнхцэцэг  
Байр хариуцсан менежер

А.Нямсүрэн  
Байр хариуцсан менежер

Нарийн бичиг:

Г.Халиунаа  
Тооцооны нягтлан бодогч